



Бүгд Найрамдах Турк улсаас Монгол Улсад суугаа
Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд МУРАТ КАРАГӨЗ:

Турк, Монголын харилцаа гэрэл гэгээтэй байна гэдэгт би итгэдэг

Сэтгүүлийнхээ "Дипломат" буланд нэгэн эрхэм зочныг урьж ярилцлаа.
Түүнийг Мурат Карагөз гэдэг. Тэрбээр Бүгд Найрамдах Турк улсаас
Монгол Улсад суугаа элчин сайд юм.

-Газар дундын тэнгис, Эгийн тэнгис, Хар тэнгисээр хүрээлүүлсэн үзэсгэлэнт Турк орон бол таны эх орон. Туркчууд монголчуудын нэгэн адил халуун цустай ард түмэн. Гэхдээ таныхаар эх орон гэж юу вэ. Энэ асуултыг ярилцлагад урьсан гадаадын эрхмүүдээс асууж байгаагүй юм байна?

-Энэ их хийсвэр асуулт байна. Мэдээж, би Турк хүн. Би Турк улсад төрсөн, Турк гэр бүлээс гаралтай. Турк орондоо өсч том болон Туркийн Засгийн газраас цалин авдаг. Энэ талаасаа ч Турк бол мэдээж, миний эх орон. Гэхдээ миний гэр бүлийн холбоо Балканы хойгийг хүртэл үргэлжилдэг. Миний хоёр өвөө өнөөгийн Болгар улсад төрсөн бөгөөд туркчууд нутгийн цөөнхийг бүрдүүлдэг. Үүний нэгэн адил миний нэг эмээ өнөөгийн Косовогийн Призрен хэмээх газар төрсөн. Энэ нутаг нь Балканы хойгийн бүсэд газрын хамт олон зууны туршид Туркийн нутаг хэмээгдэж байсан билээ. Энэ тохиолдолд Балканы хойг нь миний эх орон ч гэж хэлж болно. Монголын тухайд, энэ сайхан орон Туркийн анхны тэрт улсуудын эх орон байсан түүхтэй. Ингэхээр Монгол ч гэсэн миний эх орон гэж болно.

-Ингэхэд та хөдөө тосгонд төрж өссөн үү, эсвэл их хотын унаган иргэн үү. Туркчуудын амьдралын хэмнэл, ёс заншилд монголчуудтай төстэй зүйл байдаг болов уу?

-Би Туркийн хамгийн том хот болох Стамбулд төрсөн. Зуныхаа амралтаар хөдөө орон нутгаар их аялдаг байсан. Гэхдээ би үндсэндээ хотын хүүхэд. Монголд өнгөрүүлсэн зургаан сарын богинохон нутагсааны туршлагаас үзэхэд Турк, Монголын ард түмний хооронд ялгаатай гэхээсээ адил төстэй тал ихүү байгаа нь харагдлаа. Гэхдээ түүх, соёлоос авч ирсэн зарим зан заншил, уламжлалыг манай нөхөрсөг хоёр үндэстэн нээж илрүүлэх хэрэгтэй.

-Танай улсын түүх, соёл, газар зүйн байршил ихээхэн сонирхол татаж байна. Тэр дундаа дорно талаараа Гүрж, Армян, Азербайжан, Иран, Ирак, Сиритэй, өрнө хэсгээрээ Грек, Болгартай хол залгадаг нь геополитикийн хувьд хамгийн тал давуу тал байх, тийм үү?

-Стратегийн байршил талаасаа Турк орон бол Евро-Азийн төвд оршдог. Европ, Ази, Африк гэсэн гурван тивээр хүрээлэгдсэн. Геостратегийн байршил, түүх соёлынхоо хамт манай орны өвөрмөц байдлыг бий болгодог. Энэ нь хөршүүдтэйгээ эдийн засгийн түншлэлийг басжүүлэх үнэт баялаг юм. Турк улс нь Хар Далайн Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа (BSEC), D-8 болон Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа (ECO) зэрэг бүсийн байгууллагын гишүүн байгаа нь

MURAT KARAGOZ, Ambassador Extraordinary and Plenipotentiary of Turkey to Mongolia:

It is my firm belief that the future of Turkish and Mongolian relations are bright.

Turkey is a beautiful country surrounded by the Mediterranean, Aegean and Black Seas. The Turks are warm-blooded like the Mongolians. What is the motherland according to you? I've never asked the question from foreigners.

This is rather an abstract question. Of course, I am a Turk. I was born in Turkey and belong to a Turkish family. I grew up in Turkey and get my salary from the Turkish Government. From that perspective, certainly my motherland is Turkey. Yet, my family roots stretch out to the Balkans. Both of my grandfathers were born in today's Bulgaria, where the Turkish minority lives. Likewise, one of my grandmother was born in Prizren, today's Kosovo, which was considered along with many other places in the Balkans as homeland for Turks throughout centuries. In this case, my motherland can well be the Balkan Peninsula. And when it comes to Mongolia, this beautiful country served as homeland for the first Turkish states in the history. So, Mongolia can be my motherland, as well.

Where did you grow up, at the countryside or in a big city? Is there any similarity in the life style and habit of the Turkish and Mongolian peoples?

I was born in Istanbul, biggest city of Turkey. During summer times, I travelled countryside a lot, but in general I am a metropolitan boy. My short six months experience in Mongolia showed me that there are more similarities than differences between Turkish and Mongolian people. However, there are certain habits and traditions inherited from history and culture that need to be discovered by those two friendly nations.

The history, culture and geographical location of your country are very attractive. It borders on Georgia, Armenia, Azerbaijan, Iran, Iraq and Syria in the east and Greece and Bulgaria in the west. It is likely to be the country's advantages as for geopolitics. Is it so?



эдийн засгийн хүрээн дэх Турк улсын гадаад бодлогын олон талт шинж болон бүсийн чиглэлийг илэрхийлж байгаа билээ. Нөгөөтэйгүүр, Их хорийн (G-20) гишүүний хувьд дэлхийн эдийн засгийг удирдах хариуцлага ногдож байгаа тул Турк улсын үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байгааг харуулж байна.

Гэхдээ бидэнд тодорхой бэрхшээл бас байгаа. Турк орон хэцүү хөршүүдийн дунд, таны хэлсэнчлэн халуун цэгүүдээр хүрээлэгдэж байгаа бөгөөд манай орон тогтвортой байдлын арал болсоор байна.

- Та бол улс төр, эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн хүн. Харин Турк улстай хил залган оршдог орнуудын дотроос таны сонирхлыг хамгийн их татдаг нь аль улс вэ. Үзэсгэлэнтэй сайхан байгальтай, эртний соёлтой эдгээр оронд хөл тавьж байв уу?

Таны асуулт энгийн тайлбартай. Та машинаа, орон сууцаа, Засаг даргаа, эсвэл бүр овгоо ч сольж болно. Харин хөршөө тийм ч амар солих боломжгүй. Өнөөгийн бидний амьдарч байгаа газар нутгийг Турк хэмээн нэрлэдэг. Тэртээ 11-р зууны эхээр Анатолиагийн хаалга туркчууд бидний өмнө нээгдсэн түүхтэй. Туркийн улс төрийн газрын зураг ерөнхийдөө 20-р зуунд өнөөгийн байдлаа олсон. Сайн, муу, найз нөхөр, дайсан, ядуу, баян эсэхээс үл хамааран бид мөр зэрэгцэн амьдарч хөршүүдтэйгээ цэцэглэн хөгжих хувь тавилантай. Ирак, Сири болон Армянаас бусад бүх оронд би очиж байсан.

Turkey is strategically located at the epicenter of Eurasia. It is surrounded by three continents – Europe, Asia and Africa. Its geo-strategic location belongs with its cultural and historical depth, giving the country its uniqueness. This has been an asset in forging economic partnerships with its neighborhood. Turkish membership in regional organizations such as BSEC (Organization of the Black Sea Economic Cooperation), D – 8 and ECO (Economic Cooperation Organization) are a reflection of the multi – pronged character and regional orientation of Turkish foreign policy in the economic sphere. On the other hand, its membership in G – 20 is an indicator for its growing role as a responsible stakeholder in the global economic governance.

However, there are certain challenges as well. Hence, Turkey sits in a tough neighborhood, as you described, surrounded by hotspots, but it serves as an island of stability.

You're specialized in politics and economy. Do you single out any country from those seven countries bordered on Turkey? Have you been to these countries, known for their natural beauty and ancient culture?

Your question deserves a simple explanation. You can change your car, your job, your apartment, your mayor or even your surname. However you cannot change easily your neighborhood. The territory on which we live today is called Turkey. The gates of Anatolia opened to the Turks as early as 11th century. Today's political map of Turkey has been shaped mostly in 20th century. Good or bad, friend or foe, poor or rich we are destined to live side-by-side and to prosper together with our neighbors. With the exception of Iraq, Syria and Armenia, I visited all these countries.

One of the special features of Turkey is the country lies across Europe and Asia, and occupies quite a large territory. Do you consider you "Asian", or "European"?

Turkey has many identities. The country, its people and its deep culture have components from various geographies. Turkey is a European, Asian, Caucasian, the Middle Eastern and a Mediterranean country, all at the same time. Therefore I would rather hesitate to consider myself only as an Asian or European.

You were appointed to work at the Turkish Embassy to Bulgaria at age of 25. It is a very young age for a diplomat. Do you mind to share us with your memories?

I mentioned about my family ties in an earlier question. I was very happy when I learned that I was appointed as a junior diplomat to the Turkish Embassy in Sofia.

- Турк улсын бас нэгэн онцлог бол газар нутгийнхаа хэмжээгээр дэлхийд дээгүүрт ордог, Европ, Ази тивийг дамнан оршдог. Тэгвэл та өөрийгөө “Ази хүн” гэж боддог уу, аль эсвэл “Европ гаралтай” гэж үздэг үү?

- Турк орон олон онцлогтой. Энэ орон, түүний ард түмэн болон өнө эртний соёл нь янз бүрийн газар зүйн хэсгээс бүрддэг. Турк нь Европ, Ази, Кавказ, Ойрхи Дорнод болон Газар Дундын Тэнгисийн орон. Ийм учраас би өөрийгөө зөвхөн Ази буюу Европ хүн гэж үздэггүй.

- Та идэр залуу 25 насандаа Бүгд найрамдах Турк улсаас Болгар улсад суугаа Элчин сайдын яамны ажилтнаар томилогдсон байна. Энэ бол дипломат хүний хувьд их залуу нас. Энэ тухай дурсамжаасаа хуваалцана уу?

Манай гэр бүлийн хэлхээ холбооны талаар таны асуултын хариуд би дээр өгүүлсэн. Софи хотод Турк улсын Элчин сайдын яаманд бага тушаалын дипломат ажилтнаар томилогдсон гэдгийг мэдээд би маш их баярласан. Нэгдүгээрт, энэ оронтой би сэтгэлийн үлэмж их холбоотой. Хоёрдугаарт, энэ бол эрчимтэй харилцаатай байдаг манай хөрш орон. Ингэхээр энэ бол ахиж дэвшин зорьсондоо хүрэх боломж олгох жинхэнэ албан тушаал байсан юм. Гуравдугаарт, тэр үед Болгар улс шилжилтийн үедээ ороод байсан бөгөөд энэхүү үйл явцыг бид маш анхааралтай, ойрхноос ажиглах ёстой байсан. Эцэст нь, орчин үеийн Турк орныг үндэслэн байгуулагч Мустафа Кемал Ататуркийн 20-р зууны эхээр цэргийн атташегээр ажиллаж байсан оронд ажиллах болсондоо их бахархаж байлаа. Софид ерөнхийдөө сайхан дурсамж бүхий гайхамшигтай гурван жилийг өнгөрүүлсэн. Харин 1994 оны гуравдугаар сард өвөө, эмээ нар маань Софид над дээр зочилж, би өвөөгөө дагуулж Хасхово дахь түүний төрсөн тосгон Бзекөид 65 жилийн дараа өвөөгөө аваачсан явдал миний хувьд мартагдашгүй мөч байлаа.

- “XXI зуун бол Хятадынх” гэж нэг хэсэг ярьцгаасан. Гэтэл зарим нь “Энэ зуун Азийн зуун боллоо” гэх боллоо. Эрхэм Элчин сайд та Турк улсын Гадаад харилцааны яамны Зүүн Европ, Азийн асуудал эрхэлсэн газарт ажиллаж байсан. Мөн манай улсад Элчин сайдаар томилогдохоосоо өмнө тус яаманд Балканы орнууд болон Төв Европын асуудал эрхэлсэн газрын дэд даргын алба хашиж байсан шүү дээ. Тиймээс Ази, Европын улс төр, эдийн засгийн ертөнцөд гарч буй өөрчлөлтүүдийн талаар ямар бодол, дүгнэлттэй явдгийг тань сонирхмоор байна?

- Хэцүү асуулт байна. Хариулахад докторын зэрэг шаардлагатай байх болов уу. Миний хэлж чадах

For one, I had quite emotional ties. Secondly, it was a neighboring country with which we enjoy intense relationship. So, it was a real post of career with its challenges and opportunities. Thirdly, Bulgaria was at that time going through a transition period which we had to follow very carefully and closely. And finally, I was also proud to serve in a country when the founder of modern Turkey, Mustafa Kemal Ataturk worked as a Military Attach in early 20th century. All in all, I spent in Sofia three marvelous years, mostly with good memories. But the unforgettable moment for me was then when my grandparents visited me in March 1994 in Sofia and I escorted my grandfather to visit his home-village Beykoy, in Haskovo, after 65 years.

For some time people speak of the XXI century to be “Chinese”. However, others say it to be “Asian”. Dear Ambassador, you dealt with East Europe and Asia at the Foreign Ministry of Turkey. Also, you were at the position of deputy-chief in charge of the Balkan countries and Central Europe before being appointed as Ambassador to Mongolia. Thus, it would be interesting to know your opinion about the changes taken place in politics and economy of Asia and Europe?

It is a tough question, the answer of which may require a Ph.D. dissertation. I can only tell you that my recruitment in the Turkish Foreign Service coincides with the fall of Berlin Wall. Since then the world politics witnessed tremendous changes taking place in Europe and in Asia. It is an ongoing process. I believe we are not at the end yet. But, if the people of Europe and Asia should draw a lesson from the recent past, I guess it might be that there is no other option to build our bright future based on promoting friendship, forging cooperation and displaying solidarity in fighting common challenges rather than opting for animosity, hatred and isolation.

The Mongolian media singles you out as a person who walks a lot along the street of Ulaanbaatar. Assumed that it is to do with your wish to get closely acquainted with the Mongolians' life. Mongolia and Turkey have special relations due to the historical connection for many thousand years. What is the most exciting for you in this history, and what theme attracts you most?

From the very first moment I stepped in Mongolia, I felt that I was in an exotic country decorated with friendship, deep culture and traditions. I am very pleased that every day I spent in Mongolia helps me more to know the people, history, culture and traditions of the Mongols. It would be unfair if I chose one theme that attracts me most. But certainly the feeling of the endlessness when you leave Ulaanbaatar is compared to nothing.

зүйл гэвэл намайг Туркийн гадаад албанд орж байх тэр үе Берлиний хана нурж байсан үетэй давхцсан юм. Тэр үеэс хойш Европ болон Азид асар их өөрчлөлт гарсныг дэлхийн улс төр гэрчилж байгаа. Энэхүү үйл явц явагдсаар байна. Дуусаагүй байгаа гэж би итгэж байна. Европ, Азийн улс түмэн саяхан өнгөрсөн үеэсээ сургамж авсан бол дайсагналцах, үзэн ядах болон ганцаардуулан хавчих аргыг таягдан хаяхаас өөр хувилбар байхгүй бөгөөд ингэснээр бид найрамдлыг бэхжүүлж, хамтын ажиллагааг хөгжүүлж, нийтлэг зорилтын төлөө эв санааны нэгдэлтэй байх болов уу гэж би бодож байна.

- Таныг “Улаанбаатарын гудамжаар явган их алхдаг. Энэ нь монголчуудтай улам ойр дотно танилцах гэсэн хүсэлтэй нь холбоотой” гэж Монголын зарим хэвлэлд онцолжээ. Монгол, Турк улс бол олон мянган жилийн түүхээрээ холбогддог онцлог харилцаатай орнууд. Тэдгээрээс онцолж яримаар, сэтгэлийг тань ямагт хөдөлгөдөг нандин түүх, сонирхолтой сэдэв танд байдаг уу?

- Монголд хөл тавьсан тэр үеэс л найрамдалтай, өнө эртний соёл, уламжлалтай өвөрмөц орон гэдгийг мэдэрсэн. Монголд өнгөрүүлж байгаа өдөр бүр Монголын ард түмэн, түүний түүх, соёл болон зан заншлын талаар илүү ихийг таньж мэдэхэд тус дөхөм болж байгаад би их баярладаг. Миний сонирхлыг хамгийн ихээр татдаг хэмээн нэг л сэдвийг сонгох нь шударга биш болно.

- Элчин сайдаар томилогдсоныхоо дараахан та Монголын нэгэн телевизэд ярилцлага өгсөн. Тэгэхэд таныг уран зураг ихэд сонирхдогийг мэдсэн юм. Тэр тусмаа Монголын зураачдын бүтээлүүдийг албан өрөөндөө залсан нь анхаарал татлаа?

- Би өөрийгөө авьяастай гэж хэлж чадахгүй. Гэхдээ залуу байхдаа гитараар сонгодог хөгжим тоглож, шүлэг бичиж, драмын жүжигт тоглодог байсан. Энэ бол миний амьдралын зөвхөн нэг бяцхан ялгарах, гэхдээ үргэлжлээгүй зурвас үе. Харин гадаад албанд орсноосоо хойш янз бүрийн хүмүүс болон соёлтой харьцах илүү их боломжтой болсон. Би зураг цуглуулж эхэлсэн ба одоо ч цуглуулсаар байгаа. Монголд ирээд Монголын опера-балетын тоглолтыг ихэд шохоорхож байнга үздэг болсон. Туркийн Элчин сайдын хувиар Монголын Урлагийн Зөвлөлийн гишүүнээр ажиллаж хоёр орны соёлын харилцааг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх боломжтой болсныг бахархалтайгаар мэдэгдэж байна.

- Танай улсад хамгийн их дэлгэрсэн спорт бол хөлбөмбөг юм байна. Бүр олон улсад хэдийнэ танигдсан “Фенербахче”, “Галатасарай”,

You were interviewed by a Mongolian TV, immediately after your appointment as Ambassador. I come to know you are fond of painted pictures. Moreover, there are many pictures painted by Mongolian artists in your office. Please share us with your interest?

I cannot consider myself as a talented person. Yet, in early years of my youth I tried to play some classical guitar, to write some poems and to play drama. But this was only a small parenthesis in my life which did not continue. However, having joined the Foreign Service, I had more chance to interact with different people and different cultures. I started to collect paintings and still continue to do so. Since I came here, I became a great fan of Mongolian State Ballet and Opera, which I visit frequently. I am also proud to announce that as the Turkish Ambassador I am a member of Board of the Art Council of Mongolia through which I can help promote cultural interaction between both countries.

Football is the most common sport in Turkey. The country has several teams known to the world. Were you engaged in this sport?

It is true that football is the most popular sport in Turkey. I will not hide that I am a great fan of Fenerbahce, one of the oldest sports club in Turkey. But certainly, I support and promote the international successes of every Turkish club and team. In the past, I was actively engaged in football. I still play from time to time. I wish also to explore opportunities to make football more popular in Mongolia like wrestling, horse riding or archery.

Though you've been to Mongolia as Ambassador not long, you participate in public events very actively. You did participate in the Day of Turk Language for the 120th Anniversary to have deciphered the ancient runic script. By the way, do you learn Mongolian? Are there words of analogous meaning and pronunciation in our languages?

Let me start by correcting your question. As the Turkish Ambassador I did not only participate in, but hosted and co-sponsored the event of “Commemorating the 120th Anniversary of the Decryption of Korkut Alphabet” in MUIS. It was one of the very first cultural activities in Ulaanbaatar which got quite an attention in public opinion. I wish to learn Mongolian, but so far I could not find enough time to improve it due to heavy work load in the Embassy. As you may know, Turkish and Mongolian belong to the same language family, called Ural-Altai. There are many common words in our languages besides similar grammar structure. I feel of course happy when I discover every day a new word which is either used

“Бешикташ”, “Трабзонспор” зэрэг шигшээ багтай. Харин та энэ спортоор хичээллэж байв уу?

- Үнэхээр манай улсад хөлбөмбөг хамгийн их түгээмэл спорт болсон. Би өөрөө Туркийн спортын эртний клубуудын нэг болох “Фенербахче” багийг ихээхэн дэмждэг гэдгээ нуухгүй. Мэдээж, Туркийн бүх клуб болон багуудын олон улсын амжилтыг дэмжиж тус дөхөм үзүүлдэг. Өнгөрсөн хугацаанд хөл бөмбөгөөр идэвхтэй хичээллэж байсан. Одоо ч үе үе тоглодог. Бөхийн барилдаан, морины уралдаан, сур харвааны нэгэн адил Монгол оронд хөлбөмбөгийг илүү түгээмэл болгох боломжийг судлаасай гэж би хүсч байна.

- Хэдийгээр та Монголд Элчин сайдаар томилогдон ирээд удаагүй ч төр засаг, олон нийтийн арга хэмжээнд маш идэвхтэй оролцдог нь анзаарагдсан. Тухайлбал, эртний рүни бичгийг тайлж уншсаны 120 жилийн зориулсан түрэг хэлний өдөрлөгт оролцсон. Ингэхэд та монгол хэл сурч байгаа юу. Турк, монгол хэлэнд адил утга, дуудлагатай үгс хэр олон байна вэ?

- Таны асуултыг залруулахаас эхэлбэ. Туркийн Элчин сайдын хувьд эртний рүни бичгийг тайлж уншсаны 120 жилийн ойд зориулсан түрэг хэлний өдөрлөгт би зөвхөн оролцоод зогсохгүй, энэхүү ажлын хэрэгжүүлэгч байж хамтран санхүүжүүлж явуулсан. Энэ нь Улаанбаатар хотноо явагдсан соёлын анхны үйл ажиллагааны дотроос ихээхэн анхаарал татсан үйл явдал байсан. Би монгол хэл сурахыг хүсч байна. Гэвч Элчин сайдын яамны ажлын ачаалал их учраас хэлний мэдлэгээ дээшлүүлэх хангалттай цаг зав өнөөг хүртэл гаргаж чадахгүй л байна. Та үүнийг мэдэж байгаа байх. Монгол, Турк хоёр хэл Урал-Алтайн хэлний бүлэгт багтдаг. Манай хоёр хэлний дүрэм ижил бүтэцтэй байдгаас гадна олон тооны нийтлэг үг хэллэг байдаг. Турк болон монгол хэлээр адилхан хэрэглэгддэг буюу дуудагддаг шинэ үг өдөр бүр олж илрүүлж байгаадаа мэдээж би баяртай байдаг.

-Монгол, Турк улс дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой энэ онд тохиож байна. Нэг ёсондоо, тэрхүү түүхт явдлаас хойш бараг хагас зуун жил өнгөрч. Харин хоёр орны харилцааны түүхэнд ямар онцлог үйл явдлууд тэмдэглэгдэж үлдсэн байдаг вэ?

- 1969 онд дипломат харилцаа тогтоосноос хойш Турк, Монгол хоёр орон их амжилтанд хүрсэн гэж бид бодож байна. 1990 он хүртэл бид улс төр, цэргийн



or pronounced in the same way in Mongolian like in Turkish.

We celebrate the 45th Anniversary of establishment of diplomatic relations between Turkey and Mongolia. In another word, almost half a century has passed since the historical event. What highlights have been recorded in history of two countries' relations?



өөр, өөр бүлэглэлд багтаж байгаад Монголд ардчилал тогтож дээрх асуудал дуусгавар болсон. Өнөөдөр Турк, Монгол хоёр ойр дотно найз болж ардчиллын нийтлэг үнэт зүйлс, хуулийг дээдлэн, хүний эрх, эрх чөлөө болон чөлөөт зах зээлийн эдийн засгийг хүндэтгэж байна. Соёл, түүхийн уламжлалын сацуу эдгээр нь манай хоёр үндэстний хооронд хөдөлшгүй холбоог үүсгэж байна. Монгол Улсыг Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагад (OSCE) элсэхийг бид баяртайгаар дэмжсэн. Үүний нэгэн адил НАТО-ийн хүрээнд эрчимтэй хамтран ажиллаж байгаадаа баяртай байна. Турк, Монгол хоёр улс НҮБ, бүсийн болон олон улсын бусад байгууллагын хүрээнд ч эв санааны нэгдэлтэйгээр ажиллаж байна.

- Мурат Карагөз хэмээх эрхэм манай улсад Элчин сайдаар ажиллах хугацаандаа Монгол, Туркийн харилцаа, хамтын ажиллагаанд ямар шинэ түүхийг бичиж үлдээх бол?

- Турк, Монголын харилцааны гэрэл гэгээтэй байна гэдэгт би итгэдэг. Турк улс өөрийн хөрөнгө, чадвар, тухайлбал Туркийн хамтын ажиллагаа, зохицуулалтын байгууллага (ТИКА) болон хувийн салбарын оролцоотойгоор Монгол орны хөгжил цэцэглэлт, Монголын нөхөрсөг ард түмний сайн сайхан байдалд илүү их хувь нэмэр оруулж чадна гэж би их найдаж байна.

- Бидний асуултад цаг зав гарган хариулсанд баярлалаа. Танд амжилт хүсье.

I guess Turkey and Mongolia achieved a lot since they established their diplomatic relations in 1969. Until 1990, we belonged to different political and military blocks which ended with the democratization of Mongolia. Today, Turkey and Mongolia, as two close friends enjoy universal values of democracy, rule of law, respect for human rights and free market economy. Along with cultural and historical depth, these constitute the unshakeable ties between our nations. We happily supported membership of Mongolia to OSCE. We are equally happy that we have a robust cooperation within NATO. Turkey and Mongolia act in solidarity within UN and other regional and international institutions.

What will we expect from Your Excellency as far as the Turkish and Mongolian relations are concerned?

It is my firm belief that the future of Turkish and Mongolian relations are bright. I very much hope that Turkey with its various assets and capabilities, including TİKA (The Turkish Cooperation and Coordination Agency) and its private sector will be able to contribute more to the prosperity and well – being of the friendly people of Mongolia.

Thank you for your time and interview. I wish you success of work.